



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
АРВАЙХЭЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 04 сарын 04 өдөр

Дугаар а/39

Арвайхээр

Дэмжлэг үзүүлэх тухай

“Төсвийн тухай” хуулийн 14.2.3, сумын Засаг даргын 2016 оны а/45 дугаар захирамжаар батлагдсан “Улс, олон улсын уралдаан тэмцээн, олимпиадад оролцох хүүхэд, баг тамирчдад дэмжлэг үзүүлэх журам”-ын 2.1, 2.2 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын 2 дугаар цэцэрлэгийн ахлах бүлэгт суралцаж байгаа Г.Очирбуян нь Улаанбаатар хотод 04 дүгээр сард зохион байгуулагдах “Уран жиргээ-2017” уран уншлагын улсын уралдаанд оролцох тул 40000 /Дөчин мянга/ төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Тус сумын 6 дугаар цэцэрлэгийн “Өсөх-Ирээдүй” бүжгийн хамтлаг нь Улаанбаатар хотод 2017 оны 03 дугаар сард зохион байгуулагдсан “Дэгдээхэй нас-2017” улсын уралдаанд орон нутгаа төлөөлөн оролцсон тул 150000 /Нэг зуун тавин мянган/ төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

3. Дээрх зардалд нийт 190000 /Нэг зуун ерэн мянга/ төгрөгийг сумын орон нутгийн нөөц хөрөнгөөс гаргахыг Нягтлан бодогч /М.Отгон/-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

О.ПҮРЭВДОРЖ



14 0077